



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

### Хөрөнгө гаргах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.5.1, Улсын нөөцийн тухай хуулийн 5.1.1, 13.1.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1.Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэн аймаг, сумдад улсын нөөцөөс олгох бараа материалын хуваарийг 1 дүгээр хавсралт, Улсын нөөцөөс үнэгүй олгох өвс, тэжээлийн хуваарийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасан бараа, материалыг нөхөн бүрдүүлэхэд шаардагдах 9,775,456,944 (есөн тэрбум долоон зуун далан таван сая дөрвөн зуун тавин зургаан мянга есөн зуун дөчин дөрвөн) төгрөг, өвөлжилт, хаваржилт хүндэрсний улмаас хаагдсан зам, давааг нээх, айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, отор нүүдэл хийж байгаа малчдад эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх томилгоот бүлгүүдийн зардал болон зарим аймагт үүссэн цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэхэд зориулан 5,308,082,060 (таван тэрбум гурван зуун найман сая наян хоёр мянга жаран) төгрөг, алслагдсан сумдын эрүүл мэндийн төвд олгох эмнэлгийн зориулалттай, туулах чадвар сайтай автомашин худалдан авах зардал 9,600,000,000 (есөн тэрбум зургаан зуун сая) төгрөг, нийт 24,683,539,004 (хорин дөрвөн тэрбум зургаан зуун наян гурван сая таван зуун гучин есөн мянга дөрвөн) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Б.Жавхланд зөвшөөрсүгэй.

3.Алслагдсан сумдын эрүүл мэндийн төвд олгох автомашин худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу яаралтай зохион байгуулж, хуваарилан олгохыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт даалгасугай.

4.Өвөлжилт, хаваржилт хүндэрсэн аймаг, сумдад ажиллаж буй томилгоот бүлгүүдийн зардал, зарим аймагт үүссэн цаг үеийн асуудлыг шийдвэрлэх хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.

5.Улсын нөөцөөс гаргах бараа, материалыг 2024 онд багтаан Засгийн газрын 2023 оны 365 дугаар тогтоолд заасан бараа, материалаар нөхөн бүрдүүлэх, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд үүрэг болгосугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

С.АМАРСАЙХАН

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН


Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 63 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

УЛСЫН НӨӨЦӨӨС ОЛГОХ БАРАА, МАТЕРИАЛЫН ХУВААРЬ

№	Олгох	Нэр, төрөл	Хүлээн авах	х/н	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ	Нөхөн бүрдүүлэх бараа
1.	ОБЕГ-ын дэргэдэх 179-р анги	Хүнсний бараа	Өвөлжилт хүндэрсэн аймгуудад	багц	1,200		117,000,000	Хүнсний бараа, сав, баглаа боодол
2.	ОБЕГ-ын дэргэдэх 185-р анги	Хүний эм, хэрэгсэл		багц	500	178,500	89,250,000	Хүний эм хэрэгсэл
3.		Ажлын хувцас (дулаан)		ш	50	250,000	12,500,000	Ажлын хувцас
4.		Гипохлорид кальци	Өвөлжилт хүндэрсэн аймгуудад (сэг зэм устгах, ариутгах)	кг	25,400	7,500	190,500,000	Ариутгал, халдваргүйтгэлийн бодис
5.		Ариутгагч уусмал		литр	500	16,000	8,000,000	
6.		Мотопомп	Дорноговь аймгийн ОБГ-ын 153-р салбар	ш	1	25,250,000	25,250,000	Техник, хэрэгсэл
7.		Туулах чадвар сайтай автомашин	Архангай аймгийн Цэцэрлэг сумын ЗДТГ	ш	1	72,000,000	72,000,000	Бартаат замд зориулагдсан туулах чадвар сайтай автомашин
8.			Архангай аймгийн Цэнхэр сумын ЗДТГ	ш	1	72,000,000	72,000,000	
9.			Архангай аймгийн Өгийнуур сумын ЗДТГ	ш	1	72,000,000	72,000,000	
10.			Архангай аймгийн Эрдэнэмандал сумын ЗДТГ	ш	1	152,000,000	152,000,000	
11.	Баянхонгор аймгийн Заг сумын		ш	1	72,000,000	72,000,000		

		ЗДТГ					
12.		Баянхонгор аймгийн Жаргалант сумын ЗДТГ	ш	1	72,000,000	72,000,000	
13.		Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЗДТГ	ш	1	187,000,000	187,000,000	
14.		Баянхонгор аймгийн ОБГ	ш	1	149,000,000	149,000,000	
15.		Дорноговь аймгийн Их хэт сумын ЗДТГ	ш	1	152,000,000	152,000,000	
16.		Говь-Алтай аймгийн Бугат сумын ЗДТГ	ш	1	149,000,000	149,000,000	
17.		Увс аймгийн ОБГ	ш	1	152,000,000	152,000,000	
18.		Увс аймгийн ОБГ-ын 197-р салбар	ш	1	72,000,000	72,000,000	
19.		Сэлэнгэ аймгийн ХЦ-0243-р анги	ш	1	142,800,000	142,800,000	
20.		ОБЕГ-ын дэргэдэх 185-р анги	ш	1	72,000,000	72,000,000	
21.		ОБЕГ-ын дэргэдэх 115-р анги	ш	1	283,000,000	283,000,000	
22.		Завхан аймгийн ЗДТГ	ш	1	283,000,000	283,000,000	
23.		Сэлэнгэ аймгийн ГТУА-61-р анги	ш	1	152,000,000	152,000,000	
24.		Төв аймгийн Угтаалцайдам сумын ЗДТГ	ш	1	149,000,000	149,000,000	
25.		Төв аймгийн Эрдэнэсант сумын ЗДТГ	ш	1	187,000,000	187,000,000	
26.		УБ хот, Багануур дүүрэг	ш	1	152,000,000	152,000,000	
27.		УБ хот, Багахангай дүүрэг	ш	1	152,000,000	152,000,000	
28.		УБ хот, Налайх дүүрэг	ш	1	152,000,000	152,000,000	
29.	Автогрейдер	Дорноговь аймгийн Онцгой комисс	ш	1	350,000,000	350,000,000	Автогрейдер
<b>НИЙТ ДҮН</b>						<b>3,890,300,000</b>	





Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 63 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

### УЛСЫН НӨӨЦӨӨС ҮНЭГҮЙ ОЛГОХ ӨВС, ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ

№	Олгох	Бараа, материал	х/н	Тоо хэмжээ	Нийт үнэ	Засгийн газрын нөөц сангаас олгох дүн (төг)	Хүлээн авах
1.	Архангай аймаг	Хивэг	тн	274.00	238,370,844	238,370,844	Архангай аймгийн ЗДТГ
2.	Баян-Өлгий аймаг	Хорголжин	тн	518.08	428,883,415	428,883,415	
3.	Баянхонгор аймаг	Өвс	тн	200.00	181,200,000	181,200,000	Баянхонгор аймгийн ЗДТГ
		Хивэг	тн	310.00	293,449,200	293,449,200	
4.	Булган аймаг	Хивэг	тн	100.00	79,200,000	79,200,000	
5.	Говь-Алтай аймаг	Хивэг	тн	400.00	385,494,950	385,494,950	Говь-Алтай аймгийн ЗДТГ
6.	Дорнод аймаг	Хивэг	тн	11.00	5,410,125	5,410,125	Дорнод аймгийн ЗДТГ
7.	Говьсүмбэр аймаг	Өвс	тн	100.00	58,000,000	58,000,000	Говьсүмбэр аймгийн ЗДТГ
		Хивэг	тн	66.90	54,686,736	54,686,736	
8.	Дорноговь аймаг	Өвс	тн	100.00	57,500,000	57,500,000	Дорноговь аймгийн ЗДТГ
		Хивэг	тн	70.00	61,670,000	61,670,000	
9.	Дундговь аймаг	Өвс	тн	200.00	162,500,000	162,500,000	Дундговь аймгийн ЗДТГ
		Хивэг	тн	500.00	409,922,000	409,922,000	
10.	Завхан аймаг	Хивэг	тн	450.13	433,478,723	433,478,723	Завхан аймгийн ЗДТГ
11.	Орхон аймаг	Хивэг	тн	60.00	45,300,000	45,300,000	
12.	Өвөрхангай	Хивэг	тн	450.00	380,907,500	380,907,500	Өвөрхангай аймгийн ЗДТГ

	аймаг						
13.	Өмнөговь аймаг	Өвс	тн	250.00	195,500,000	195,500,000	
		Хивэг	тн	1,020.00	936,219,400	936,219,400	
14.	Сүхбаатар аймаг	Хивэг	тн	48.85	43,003,695	43,003,695	Сүхбаатар аймгийн ЗДТГ
15.	Төв аймаг	Хивэг	тн	186.90	145,610,000	145,610,000	Төв аймгийн ЗДТГ
16.	Увс аймаг	Хивэг	тн	285.00	231,385,800	231,385,800	Увс аймгийн ЗДТГ
17.	Ховд аймаг	Хорголжин	тн	199.00	174,674,964	174,674,964	
18.	Хөвсгөл аймаг	Хивэг	тн	150.00	126,441,000	126,441,000	Хөвсгөл аймгийн ЗДТГ
19.	ОБЕГ-ын дэргэдэх 185-р дугаар анги	Хивэг	тн	710.55	548,780,534	548,780,534	Хэнтий, Сүхбаатар аймгийн ЗДТГ, бусад аймаг, дүүрэгт
		Бэлдмэл	ш	1,500	10,600,000	10,600,000	
		Тээврийн зардал	төг			196,968,058	Хэнтий, Сүхбаатар аймагт тэжээл тээвэрлэн байршуулах
НИЙТ ДҮН		Өвс		850	654,700,000	654,700,000	
		Тэжээл		5,810	5,033,488,886	5,033,488,886	
		Тээврийн зардал		-	-	196,968,058	
				6,660.41	5,688,188,886	5,885,156,944	